


Үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжид үүссэн чичиргээ бүр ‘аюулгүй чичиргээ*’ биш

2020 оны 11-р сар

Зарим тоног төхөөрөмж, тухайлбал чичиргээт конвейер болон шигшигч зэрэг нь хөдөлгөөнтэй байх зориулалттай. Харин бусад тоног төхөөрөмжийн хувьд ихэвчлэн доргио чичиргээ тохиромжгүй бөгөөд тухайн тоног төхөөрөмжийг эсвэл шугам хоолойг гэмтээх, урьдчилан тооцоолоогүй эвдрэл үүсгэх эрсдэлтэй.



Даралт хэмжигч хэрэгслийн холболтын алдаа

Шинэ компрессорын системийг ашиглалтад оруулсан байсан (Зураг А). Түр засварын үед даралт хэмжигч хэрэгслийн холболтыг өөрчилсөн ба (Зураг В) уг даралт хэмжигчийг урт шугам хоолойд дахин угсарч тогтоосон. Компрессор болон шугам хоолойны чичиргээний улмаас хөдөлгөөн ихэссэн тул холболтод алдаа гарч их хэмжээний шатамхай уур алдагдсан. Азаар гал ноцоогүй боловч байгаль орчинд их хэмжээний материал алдагдсан (Зураг С).

Өөр нэг ослын жишээ: Тойрох үзлэг хийж байсан оператор 1 инч (25 см) орчим хэмжээтэй хөдөлгөөнд буй шугам хоолойг олж тогтоожээ. Түүний хэлснээр тус тохиолдол нь ууршуулагч аппаратны дээрх роторын тэнцвэр алдагдсан үед ажиглагдсан байна. Тэрхүү тэнцвэргүй байдал нь ашиглалтын чанарын түвшинг 50% бууруулжээ. Үндсэн холхивчууд болон ууршуулагчийн роторыг зассаны дараа хөдөлгөөн зогссон бөгөөд ашиглалтын түвшин хэвийн хэмжээндээ буцаж хүрсэн.

Та мэдэх үү?

- Дараах зүйлсийн нөлөөгөөр чичиргээ үүсэх боломжтой:
 - Эргэлтэт тоног төхөөрөмжийн тэнцвэр алдагдах
 - Урсгалаас үүссэн чичиргээ
 - Цохилтот тоног төхөөрөмж (солилцох насос гэх мэт)
 - Далайн давалгааны нөлөөнд өртдөг тоног төхөөрөмж
- Шингэний урсгалыг гэнэт өгөх эсвэл зогсоох үед хүчтэй цохилт эсвэл ‘балбалт’ үүсэх боломжтой.
- Чичиргээг тусгаарлахын тулд уян холболтууд ашиглаж болох боловч тэдгээр нь хэврэг материалаар хийгддэг тул гэмтэх боломжтой.
- Эргэлтэт тоног төхөөрөмжүүдэд дохиололтой доргилт хянах мэдрэгч угсарч болох ба хэт их доргилт үүсэх, эвдрэл гэмтэл учирч болзошгүй нөхцөлд дохиолол идэвхждэг.
- Хөдөлгөөний далайц болон давтамж нь тухайн доргилтод өртсөн тоног төхөөрөмжийн эвдрэл гэмтэх хурдад нөлөөлдөг.
- Доргилт чичиргээний тест, дүн шинжилгээг хийж эх үүсвэрийг нь тогтоох зориулалттай технологи байдаг.

Та юу хийж болох вэ?

- Үйлдвэрийн талбайгаар алхах үедээ чичиргээт тоног төхөөрөмжүүдийг ажиглаж, сонсож байх хэрэгтэй. Доголдолтой зүйл илэрвэл ахлах ажилтандаа мэдээл. Засвар үйлчилгээний үзлэгээр бүрэн хянагдаагүй ямар нэгэн зүйлийг та харах эсвэл сонсох боломжтой юм.
- Чичиргээний түвшинд үүссэн өөрчлөлт нь анзаарагдахгүй байж болзошгүй. Хэрэв чичиргээний түвшин улам дордож байвал эвдрэл гэмтэл үүсэх эрсдлийг илтгэж болно.
- Чичиргээ хянах төхөөрөмжийн дохиолол идэвхжих нь тоног төхөөрөмжид гэмтэх эрсдэл байгааг илтгэдэг учир үүнд бусад анхааруулах дохиоллын адил нухацтай хандах хэрэгтэй. Шугам хоолой эсвэл тоног төхөөрөмж чичиргээтэй байгааг анзаарвал тоног төхөөрөмжийн эвдрэл гэмтлийг мэдээлэх журмын дагуу арга хэмжээ ав.

* https://www.youtube.com/watch?v=Eab_beh07HU

Чичиргээ үүсэх нь ямар нэгэн зүйл доголдсон болохыг илтгэдэг. Анхааралтай сонс!